



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2025/023/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn Сүхбаатар сум 2025 он	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа	
	Утас:7036-3040	Цахим хаяг: Enkhtuyach@audit.gov.mn
	Аудитын менежер: Б.Батмөнх	
	Утас: 7036-3036	Цахим хаяг: Batmunkhb@audit.gov.mn
	Аудитор:	Э.Энхбүрэн
	Утас: 7036-2442	Цахим хаяг: Enkhburene@audit.gov.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын дүгнэлт	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5-13
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	13-18
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	13
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	14-15
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	15
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	16-18
4. Аудитын тайлан	18-21
4.1 Ерөнхий зүйл	18
4.2 Материаллаг байдал	19
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	19
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	19
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	20
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	20-21
5. Аудитын илрүүлэлт	21-22
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	23

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БОАЖС	Байгаль орчин аялал жуулчлалын сайд
БОУАӨС	Байгаль орчин уур амьсгалын өөрчлөлтийн сайд
УЦУОШТ	Ус цаг уур орчны шинжилгээний төв
ТБОНӨХБАҮХАТ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЦУОШГ	Цаг уур, орчны шинжилгээний газар



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН УС ЦАГ УУР,
ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВИЙН ДАРГА
О.ГАНБАТ ТАНАА**

2025.02.19 № СЭА-2025/023/НА-СТА-ТШЗ

танай _____-ны № _____

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд тус төв нь ЦУОШГ-аас 246,489.7 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 4,840.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл, 1,500.0 мянган төгрөгийн санхүүгийн программ хангамжийг үнэ төлбөргүйгээр шилжүүлэн авсан байна.

Аудитын гол асуудал

Дээд шатны төсвийн захирагчаас тус газрын тайлант оны төсвийн төлөвлөлт, хуваарилалтыг тухайн сарын гүйцэтгэлд үндэслэн тайлант онд нийт 5 удаа өөрчилж, зохицуулалт хийж байгаа буюу бодит гүйцэтгэлтэй уялдуулан өөрчилж байгаа нь төсвийн төлөвлөлтийг тооцоо, судалгаанд үндэслэн бодитоор төлөвлөдөггүй болохыг харуулж байна.

432502731 3

Бусад асуудлын хэсэг

Сэлэнгэ аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төв нь тайлант оны "Гүйцэтгэлийн төлөвлөгөө"-г 4 зорилтын хүрээнд 48 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, биелэлтийг 99.92 хувьтай үнэлүүлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>123,649,163.27</u>	<u>126,491,381.07</u>
33	АВЛАГА	9,300,000.00	
33300	Татаас санхүүжилтийн авлага	9,300,000.00	
35	БАРАА МАТЕРИАЛ	114,349,163.27	126,491,381.07
351	Түүхий эд материал	50,642,502.69	57,059,548.20
35110	Тусгай зориулалттай материал	50,642,502.69	57,059,548.20
354	Хангамжийн материал	63,706,660.58	69,431,832.87
35410	Бичиг хэргийн материал	1,127,200.00	323,200.00
35420	Аж ахуйн материал	5,150,180.58	24,353,162.87
35430	Сэлбэг хэрэгсэл	19,014,980.00	18,672,750.00
35440	Түлш, шатах тослох материал	1,750,000.00	1,475,000.00
35450	Барилгын засварын материал	24,639,000.00	
35470	Бусад хангамжийн материал	12,025,300.00	24,607,720.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>826,621,651.59</u>	<u>1,169,875,925.82</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	826,621,651.59	1,169,875,925.82
392	Биет хөрөнгө	565,948,651.51	907,945,425.70
39201	Барилга, байгууламж, орон сууц	399,282,534.09	516,075,687.09
39202	Хуримтлагдсан элэгдэл	(86,927,314.50)	(104,016,286.64)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	104,767,573.78	109,607,573.78
39204	Хуримтлагдсан элэгдэл	(70,698,727.68)	(94,129,156.66)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	388,960,971.33	696,163,169.33
39206	Хуримтлагдсан элэгдэл	(174,457,106.43)	(221,750,427.85)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	16,988,560.00	14,449,000.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(11,967,839.08)	(8,454,133.35)
393	Биет бус хөрөнгө	260,673,000.08	261,930,500.12
39301	Программ хангамж	275,000.00	1,775,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(109,999.92)	(352,499.88)
39303	Бусад биет бус хөрөнгө	260,508,000.00	260,508,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>950,270,814.86</u>	<u>1,296,367,306.89</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	<u>9,300,000.00</u>	
413	Өглөг	9,300,000.00	
41361	Байгууллагад төлөх өглөг	9,300,000.00	
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>940,970,814.86</u>	<u>1,296,367,306.89</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	940,970,814.86	1,296,367,306.89
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,295,182,634.93	1,295,182,634.93
51101	Өмч: - төрийн	1,295,182,634.93	1,295,182,634.93
512	Хуримтлагдсан үр дүн	(479,052,168.74)	(123,655,676.71)
51210	Өмнөх үеийн үр дүн	(479,052,168.74)	(479,052,168.74)

51220	Тайлант үеийн үр дүн		355,396,492.03
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	124,840,348.67	124,840,348.67
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>950,270,814.86</u>	<u>1,296,367,306.89</u>

1324100015 9055435

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,176,027,519.70	3,630,757,086.36
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	52,507,419.70	404,377,586.36
120	Нийтлэг татварын бус орлого	52,507,419.70	404,377,586.36
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,165,000.00	1,000,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,165,000.00	1,000,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого үндсэн хөрөнгө	37,506,007.98	344,967,891.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого бараа материал	13,836,411.72	58,409,695.36
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,123,520,100.00	3,226,379,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,069,255,400.00	3,128,130,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,069,255,400.00	3,128,130,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	54,264,700.00	98,249,500.00
131103	ЗГНХ, ЗДНХ хөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	34,505,200.00	30,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,280,000.00	39,400,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	9,479,500.00	28,849,500.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,106,112,804.17	3,275,246,011.12
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,106,112,804.17	3,275,246,011.12
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,014,523,248.94	3,082,989,188.18
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,525,103,228.00	2,427,514,363.00
210101	Үндсэн цалин	973,282,692.00	1,354,046,098.00
210102	Нэмэгдэл	314,056,788.00	656,889,333.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	125,583,677.00	239,515,263.00
210104	Урамшуулал	112,180,071.00	177,063,669.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	190,631,477.00	303,597,792.00
210201	Тэтгэврийн даатгал	130,157,500.00	206,823,000.00
210202	Тэтгэмжийн даатгал	15,119,800.00	24,195,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	12,095,600.00	13,007,577.00
210204	Ажилгүйдлийн даатгал	3,023,800.00	11,187,823.00
210205	Эрүүл мэндийн даатгал	30,234,777.00	48,384,092.00

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	67,745,082.82	65,623,648.50
210301	Гэрэл, цахилгаан	14,338,087.86	18,317,500.00
210302	Түлш, халаалт	49,570,995.51	42,195,148.50
210303	Цэвэр, бохир ус	3,835,999.45	5,111,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	43,155,509.95	39,693,324.77
210401	Бичиг хэрэг	4,475,790.00	2,311,000.00
210402	Тээвэр, шатахуун	21,893,100.00	19,959,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,162,827.95	2,824,208.56
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	240,000.00	260,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,115,970.00	6,789,898.00
210408	Бараа материал акталсны зардал	3,267,822.00	7,548,717.71
2105	Нормативт зардал	2,611,090.00	3,859,280.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,194,090.00	3,859,280.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	417,000.00	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	46,568,286.80	99,517,501.35
210601	Багаж, техник, хэрэгсэл	8,990,036.80	47,417,701.35
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	1,103,080.00	215,000.00
210604	Урсгал засвар	36,475,170.00	51,884,800.00
2107	Томилолт, зочны зардал	10,250,000.00	8,336,800.00
210702	Дотоод албан томилолт	10,250,000.00	8,336,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,753,273.00	11,418,445.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,813,800.00	9,688,080.00
210803	Даатгалын үйлчилгээ	775,100.00	355,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	324,015.00	313,107.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	154,000.00	132,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	137,800.00	381,200.00
210807	Газрын төлбөр	548,558.00	548,558.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	119,705,301.37	123,428,033.56
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	119,705,301.37	123,428,033.56
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	91,589,555.23	192,256,822.94
2132	Бусад урсгал шилжүүлэг	81,822,597.00	192,030,680.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал		39,400,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	75,722,597.00	149,630,680.00
213209	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	6,100,000.00	3,000,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	9,766,958.23	226,142.94
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	9,766,958.23	226,142.94
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	0.00	0.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	9,766,958.23	226,142.94
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	69,914,715.53	355,511,075.24

	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (5)		114,583.21
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз		114,583.21
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (6)=(4)-(5)		(114,583.21)
	НИЙТ ҮР ДҮН (7)=(3)+(6)	69,914,715.53	355,396,492.03

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	2,124,685,100.00	3,227,379,500.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,165,000.00	1,000,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,165,000.00	1,000,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,165,000.00	1,000,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,165,000.00	1,000,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,123,520,100.00	3,226,379,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,069,255,400.00	3,128,130,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,069,255,400.00	3,128,130,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	54,264,700.00	98,249,500.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	34,505,200.00	30,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,280,000.00	39,400,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	9,479,500.00	28,849,500.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	2,006,619,314.00	3,105,550,500.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,006,619,314.00	3,105,550,500.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,915,029,758.77	2,913,293,677.06
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,525,103,228.00	2,427,514,363.00
210101	Үндсэн цалин	949,193,828.00	1,251,650,900.00
210102	Нэмэгдэл	337,180,700.00	763,933,463.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	125,616,000.00	240,273,200.00
210104	Урамшуулал	113,112,700.00	171,656,800.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	190,631,477.00	303,597,792.00
210201	Тэтгэврийн даатгал	130,157,500.00	206,823,000.00
210202	Тэтгэмжийн даатгал	15,119,800.00	24,195,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	12,095,600.00	12,097,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	3,023,800.00	12,097,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	30,234,777.00	40,384,092.00

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	66,745,082.82	65,416,148.50
210301	Гэрэл, цахилгаан	14,338,087.86	18,317,500.00
210302	Түлш, халаалт	48,570,995.51	41,987,648.51
210303	Цэвэр, бохир ус	3,835,999.45	5,111,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	39,714,827.95	30,130,428.56
210401	Бичиг хэрэг	5,169,950.00	2,046,400.00
210402	Тээвэр, шатахуун	21,893,100.00	19,692,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,162,827.95	2,824,208.56
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	240,000.00	260,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,248,950.00	5,307,820.00
2105	Нормативт зардал	3,501,090.00	3,859,280.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,194,090.00	3,859,280.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,307,000.00	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	70,330,780.00	29,493,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,707,100.00	982,500.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	6,535,980.00	209,400.00
210604	Урсгал засвар	61,087,700.00	28,301,600.00
2107	Томилолт, зочны зардал	10,250,000.00	8,336,800.00
210702	Дотоод албан томилолт	10,250,000.00	8,336,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,753,273.00	44,945,365.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,813,800.00	43,215,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	775,100.00	355,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	324,015.00	313,107.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	154,000.00	132,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	137,800.00	381,200.00
210807	Газрын төлбөр	548,558.00	548,558.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	91,589,555.23	192,256,822.94
2132	Бусад урсгал шилжүүлэг	81,822,597.00	192,030,680.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал		39,400,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	75,722,597.00	149,630,680.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,100,000.00	3,000,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	9,766,958.23	226,142.94
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	9,766,958.23	226,142.94
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	00.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	118,065,786.00	121,829,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	118,065,786.00	121,829,000.00

22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	118,065,786.00	121,829,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	118,065,786.00	121,829,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	118,065,786.00	121,829,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	118,065,786.00	121,829,000.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

К о д	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2023 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	1,034,672,634.93	49,147,200.59	(555,840,532.40)	527,981,303.12
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	2,428,208.30	2,428,208.30
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,034,672,634.93	49,147,200.59	(553,412,324.10)	530,409,511.42
4	Дахин үнэлгээний нэмэгдэл, хэрэгжсэн дүн	0.00	(2,428,208.30)	0.00	(2,428,208.30)
5	Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний гарз	0.00	0.00	0.00	0.00
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз	0.00	0.00	0.00	0.00
7	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	(137,893,671.17)	(137,893,671.17)
8	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,295,182,634.93	124,840,348.67	(479,052,168.74)	940,970,814.86
9	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,295,182,634.93	124,840,348.67	(479,052,168.74)	940,970,814.86
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
11	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,295,182,634.93	124,840,348.67	(479,052,168.74)	940,970,814.86
12	Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
13	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00
14	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	355,396,492.03	355,396,492.03
15	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,295,182,634.93	124,840,348.67	(123,655,676.71)	1,296,367,306.89

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэтрэлт/хэмнэлт	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,129,130,000.00	3,128,903,857.06	226,142.94	100.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,129,130,000.00	3,128,903,857.06	226,142.94	100.0

210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,979,499,300.00	2,979,273,177.06	226,122.94	100.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,419,539,200.00	2,419,514,363.00	24,837.00	100.0
210101	Үндсэн цалин	1,243,650,900.00	1,243,650,900.00	-	100.0
210102	Нэмэгдэл	763,958,300.00	763,933,463.00	24,837.00	100.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	240,273,200.00	240,273,200.00	-	100.00
210104	Урамшуулал	171,656,800.00	171,656,800.00	-	100.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	302,442,300.00	302,435,692.00	6,608.00	99.98
210201	Тэтгэврийн даатгал	205,660,900.00	205,660,900.00	-	100.00
210202	Тэтгэмжийн даатгал	24,195,300.00	24,195,300.00	-	100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	12,097,700.00	12,097,700.00	-	100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	12,097,700.00	12,097,700.00	-	100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	48,390,700.00	48,384,092.00	6,608.00	99.98
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	65,416,500.00	65,416,148.50	351.50	99.99
210301	Гэрэл, цахилгаан	18,317,500.00	18,317,500.00	-	100.00
210302	Түлш, халаалт	41,988,000.00	41,987,648.50	351.50	99.99
210303	Цэвэр, бохир ус	5,111,000.00	5,111,000.00	-	100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	12,420,700.00	12,322,308.56	98,381.44	99.20
210401	Бичиг хэрэг	696,400.00	696,400.00	-	100.00
210402	Тээвэр, шатахуун	8,392,000.00	8,392,000.00	-	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,550,000.00	2,549,208.56	791.44	99.96
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	357,600.00	260,000.00	97600	72.7
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	424,700.00	424,700.00	-	100.00
2105	Нормативт зардал	1,307,000.00	1,307,000.00	-	100.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл				
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,307,000.00	1,307,000.00	-	100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	130,682,500.00	130,682,500.00	-	100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	93,511,500.00	93,511,500.00	-	100.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	209,400.00	209,400.00	-	100.00
210604	Урсгал засвар	36,961,600.00	36,961,600.00	-	100.00
2107	Томилолт, зочны зардал	4,336,800.00	4,336,800.00	-	100.00
210702	Дотоод албан томилолт	4,336,800.00	4,336,800.00	-	100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	44,661,300.00	44,465,365.00	95,935.00	100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	42,835,000.00	42,835,000.00	-	100.00
210803	Даатгалын үйлчилгээ	355,500.00	355,500.00	-	100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	409,000.00	313,107.00	95,893.00	76.6
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	132,000.00	132,000.00	-	100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	381,200.00	381,200.00	-	100.00

210807	Газрын төлбөр	548,600.00	548,558.00	42.00	100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	149,630,700.00	149,630,680.00	20.00	100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	149,630,700.00	149,630,680.00	20.00	100.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	149,630,700.00	149,630,680.00	20.00	100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	-	-	-
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,129,130,000.00	3,128,903,857.06	226,142.94	100.00
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	3,129,130,000.00	3,127,903,857.06	226,142.94	100.00
310001	Улсын төсвөөс санхүүжих	3,129,130,000.00	3,127,903,857.06	226,142.94	100.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,000,000.00	1,000,000.00	-	100.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,000,000.00	1,000,000.00	-	100.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	-	100.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	-	100.00
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	80.00	77.00	3.00	96.25
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	76.00	73.00	3.00	96.05
620003	Үйлчлэх ажилтан	3.00	3.00	-	100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	98,249,500.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	98,249,500.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	55,849,500.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	8,000,000.00
210101	Үндсэн цалин	8,000,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,162,100.00
210201	Тэтгэврийн даатгал	1,162,100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	17,808,120.00
210401	Бичиг хэрэг	1,350,000.00
210402	Тээвэр, шатахуун	11,300,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	275,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,883,120.00
2105	Нормативт зардал	3,859,280.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,859,280.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,340,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	
210602	Тавилга, эд хогшил	
210604	Урсгал засвар	11,340,000.00
2107	Томилолт, зочны зардал	4,000,000.00
210702	Дотоод албан томилолт	4,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,680,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,680,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	42,400,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	42,400,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,000,000.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	39,400,000.00

213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	39,400,000.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	98,249,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	98,249,500.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	30,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	39,400,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	28,849.500.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сэлэнгэ аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төв нь "Ус, цаг агаар, байгаль орчны төлөв байдалд байнгын хяналт шинжилгээ хийж, бодит болон урьдчилан сэргийлэх мэдээ, мэдээллээр нийгмийн хэрэгцээг шуурхай хангах, байгалийн болзошгүй гамшигийн эрсдэлээс сэрэмжлүүлэх" гэсэн эрхэм зорилгын хүрээнд дараах чиг үүргийг хэрэгжүүлэн ажилласан байна. Үүнд:

- Ус цаг уур орчны төлөв байдлын урьдчилсан болон горимын үнэн зөв мэдээ, мэдээллээр төр засаг, аж ахуйн нэгж байгууллага, иргэдэд шуурхай үйлчлэх
- Нутаг дэвсгэртээ нислэг үйлдэж буй агаарын хөлгийн нислэгт цаг агаарын бодит болон урьдчилсан мэдээгээр үйлчилж нислэгийн аюулгүй байдлыг хангах
- Байгаль цаг агаарын болзошгүй аюултай болон гамшигт үзэгдэл, орчны ноцтой бохирдлоос сэрэмжлүүлэх
- Ус цаг уур орчны хяналт шинжилгээний өртөө, харуулуудыг арга зүйн удирдлагаар хангаж, тэдгээрийн тасралтгүй ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, холбоо, мэдээлэл сүлжээний найдвартай ажиллагаа, хэмжлийн нэгдмэл байдлыг хангах
- Шинжилгээний зориулалттай хэмжих хэрэгслийн хангалт, техник технологийн шинэчлэлтийг хэрэгжүүлэх, багаж төхөөрөмж материалын нэгдсэн судалгаа гаргах, ашиглалтад хяналт тавих
- Шинжилгээ мэдээлэл үйлчилгээний ажлын чиглэлээр гарч буй дүрэм заавар, стандартыг мөрдөж хэрэгжүүлэх
- Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааг зохицуулах
- Ажилтнуудын ажиллах нөхцөл, нийгмийн асуудлыг сайжруулах, ажилд нь сургаж дадлагажуулах, мэргэжлийг нь дээшлүүлэх

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомж, бодлого журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой өөрчлөлт,
- Нийгмийн даатгалын ерөнхий хуульд 2024 оны 06 дугаар сарын 05-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Хөдөлмөрийн тухай хуульд 2024 оны 01 дүгээр сарын 12, 06 дугаар сарын 05 -нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2024 оны 01 дүгээр сарын 17, 12 дугаар сарын 12-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Төрийн албаны тухай хуульд 2024 оны 05 дугаар сарын 16, 06 дугаар сарын 05-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 128 дугаар тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон гэх мэт.

Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн санхүүгийн үйл ажиллагаанд ЦУОШГ-ын Захиргаа, аудитын хэлтсээс дотоод хяналт тавьдаг бөгөөд тайлант онд сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан төсвийн дотоод хяналтыг хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

ЦУОШГ-ын даргын 2023 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн А/163 дугаар тушаалаар Цаг уур, орчны шинжилгээний салбарын хэмжээнд мөрдөгдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталсан байна.

Тус төвийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/3 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 346,459.1 мянган төгрөгөөр буюу 36.5 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	9,300.0	-	(9,300.0)
Бараа материал	114,349.2	126,491.4	12,142.2
Үндсэн хөрөнгө	826,621.6	1,169,875.9	343,254.3
Нийт хөрөнгө	950,270.8	1,296,367.3	346,096.5
Өр төлбөр	9,300.0	-	(9,300.0)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	940,970.8	1,296,367.3	355,396.5
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	950,270.8	1,296,367.3	346,096.5

Дээрх хүснэгтээс харахад, нөлөө бүхий өөрчлөлт гарсан дараах данс байна.

Үүнд:

- Авлага болон өр төлбөр дансны үлдэгдэл 9,300.0 мянган төгрөгөөр буурсан нь татаас санхүүжилтийн авлагыг авч урсгал засварын гэрээт ажлын үлдэгдлийг шилжүүлснээс,
- Бараа материалын дансны үлдэгдэл 126,491.4 мянган төгрөг болж 12,142.2 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 96,489.0 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, ЦУОШГ-аас 58,119.7 мянган төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүйгээр хүлээн авсан болон 7,548.7 мянган төгрөгийн бараа материалыг акталж, устган, 135,207.7 сая төгрөгийн бараа материалыг зарцуулснаас,
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,169,875.9 мянган төгрөг болж 343,254.3 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 179,522.2 мянган төгрөгийн компьютер, тоног төхөөрөмжийг худалдан авч, ЦУОШГ-аас 252,829.7 мянган төгрөгийн компьютер, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг үнэ төлбөргүйгээр хүлээн авснаас тус тус шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 2,565,479.6 мянган төгрөг, өөрийн орлогоос 1,000.0 мянган төгрөг буюу нийт 2,566,479.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 129,934.1 мянган төгрөгөөр өсгөж **2,696,413.7** мянган төгрөгөөр баталсан байна. Үүнд:

- Цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардлыг 289,336.8 мянган төгрөгөөр,
- Ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын зардлыг 36,167.0 мянган төгрөгөөр,
- Урсгал шилжүүлгийн зардлыг 4,566.7 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлэн
- Байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 23,443.5 мянган төгрөгөөр,
- Хангамж, бараа материалын зардлыг 37,253.1 мянган төгрөгөөр,
- Эд хогшил, урсгал засварын зардлыг 76,968.3 мянган төгрөгөөр,
- Нормативт зардлыг 10,346.7 мянган төгрөгөөр,
- Албан томилолтын зардлыг 25,603.3 мянган төгрөгөөр,
- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийг 17,899.4 мянган төгрөгөөр
- Бараа үйлчилгээний бусад зардлыг 8,622.0 мянган төгрөгөөр тус тус бууруулсан байна.

Төсвийн жилийн дундуур батлагдсан төсвийг нийт 5 удаа шинэчлэн 432,716.3 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, **3,129,130.0** мянган төгрөг болгон эцэслэн баталсан байна. Үүнд:

- Цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардлыг 225,000.0 мянган төгрөгөөр,
- Төрийн албан хаагчдын цалин нэмэгдсэнтэй холбоотойгоор цалин хөлс болон ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлыг 28,125.0 мянган төгрөгөөр,
- Хангамж, бараа материалын зардлыг 5,889.9 мянган төгрөгөөр,
- Эд хогшил, урсгал засварын зардлыг 129,180.8 мянган төгрөгөөр,
- Албан томилолтын зардлыг 3,640.1 мянган төгрөгөөр,
- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийг 37,016.1 мянган төгрөгөөр,

- Нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлыг 13,993.3 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн бол,
- Байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 9,989.0 мянган төгрөгөөр,
- Нормативт зардлыг 139.9 мянган төгрөгөөр бууруулсан гэх мэт.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 3,128,130.0 мянган төгрөгийг улсын төсвөөс, 1,000.0 мянган төгрөгийг үйл ажиллагааны өөрийн орлогоос бүрдүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлээр улсын төсвөөс 3,128,903.8 мянган төгрөгийн санхүүжилт авч, үйл ажиллагааны өөрийн орлого 1,000.0 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 3,128,903.8 мянган төгрөг буюу 99.9 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 226.1 мянган төгрөгөөр хэмнэсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт /хувиар/
1	Ус цаг уур, орчны шинжилгээ, Үндсэн үйл ажиллагааны зардал	2,972,298.6	2,972,293.7	4.9	99.9
2	Ус цаг уур, орчны шинжилгээ, Холбооны суваг ашигласны хөлс	6,200.7	6,200.7	0.0	100.0
3	Ус цаг уур, орчны шинжилгээ, Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	149,630.7	149,630.7	0.0	100.0
	Дүн	3,128,130.0	3,128,125.1	4.9	99.9

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "Нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус газрын нэмэлт санхүүжилтийн 100130013404 тоот дансанд төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 19,549.5 мянган төгрөг, Байгаль орчин, Уур амьсгалын өөрчлөлтийн сайдын 2024 оны А/885 тушаалаар дахин хуваарилсан 39,400.0 мянган төгрөг, аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс цаг агаарт зориудаар нөлөөлж, хур тунадас, нэмэгдүүлэх

ажлын 30,000.0 мянган төгрөг, урьд оны татаас санхүүжилтийн авлагын 9,300.0 мянган төгрөг зэрэг нийт 98,249.5 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлэн, 98,249.5 мянган төгрөгийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

1324156615 9055436

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд дараах худалдан авах ажиллагааны урилгыг ТБОНӨХБАҮХАТ хуульд заасны дагуу tender.gov.mn-д цахим сайтад байршуулж, зохион байгуулсан байна. Үүнд:

№	Тухайн жилд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний нэр төрөл, тоо, хэмжээ, хүчин чадал	Батлагдсан төсөв	Гэрээний дүн	/мянган төгрөгөөр/ Худалдан авах ажиллагаанд мөрдөх журам /Тендер шалгаруулалтын арга/
				Харьцуулалтын арга
1	"УЦУОШТ-ийн өргөтгөлийн дээврийн их засварын ажил"	42,800.0	42,693.2	Харьцуулалтын арга

Аймгийн Худалдан авах ажиллагааны газраас худалдан авах ажиллагааг харьцуулалтын аргаар зохион байгуулан, хамгийн бага үнийн санал ирүүлсэн "Есөн хэлхээ" ХХК гүйцэтгэгчээр шалгаран, гэрээний хугацаанд хийж гүйцэтгэн хүлээлгэн өгсөн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Э.Энхбүрэн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 07/26 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2,106,112.8 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 21,061.1 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тус төв нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Бичгийн цаас, принтерийн хорны зардлыг хэмнэх зорилгоор бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтөд дотоод сүлжээг ашигласан,
- Байгууллагын үндсэн үйл ажиллагаатай холбоотой бус сурталчилгаа, кино контент, тэмдэглэлт ой, баяр ёслолын арга хэмжээг зохион байгуулаагүй, төсвийн хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдаж аваагүй,
- Тээврийн хэрэгслүүдийн дугаарыг цэнхэр дэвсгэр бүхий тусгай дугаараар сольсон,
- Хэвлэл захиалгын төлбөр гаргалгүй ажилласан зэрэг төсвийн шууд захирагчтай хамааралтай заалтуудыг мөрдөж, батлагдсан төсвийн хүрээнд ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн мэдээлбэл зохих 165 мэдээллийг бүрэн мэдээлсэн байна.

Шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторов 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 173 дугаар "Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай" албан бичгийг хүргүүлсэн бөгөөд завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгөгдсөн акт, албан шаардлага, зөвлөмжийг бүрэн биелүүлсэн байна.

Хүснэгт 3. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	1	-	1	-	100
Албан шаардлага	2	18,119.0	2	18,119.0	100
Акт	1	1,304.6	1	1,304.6	100
Нийт дүн	4	19,423.6	4	19,423.6	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Сэлэнгэ аймгийн Цаг уур орчны шинжилгээний төвийн төсвийн шууд захирагчийн бус дээд шатны төсвийн захирагчийн шийдвэрээр хэрэгжсэн дараах асуудлыг дээд шатны төсвийн захирагчийн санхүүгийн тайланд хийх аудитын анхааралд хандуулж байна. Үүнд:

1. БОУАӨС-ын даргын 2024 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн А/880, ЦУОШГ-ын даргын 12 дугаар сарын 17-ны өдрийн А/366 тушаалуудаар "Төсвийн захирагчийн 2023 оны төсвийн гүйцэтгэл, санхүүжилтийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлэн тайлагнаж, жилийн эцсийн санхүүгийн тайланд хийгдсэн аудитын дүгнэлтээр "Өөрчлөлтгүй" дүгнэгдсэн байгууллагын төсвийн шууд захирагч, нягтлан бодогч, нярав нарт нэг сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшууллыг олгохыг зөвшөөрсүгэй" гэж хууль, эрх зүйн үндэслэлгүй шийдвэр гаргаж, ирүүлсэн байна.

Дээрх тушаалуудын дагуу дараах албан хаагчдын ажлын үр дүнг улирал бүр дүгнэж, үндсэн цалингийн 50.0 хүртэл хувиар тооцон үр дүнгийн мөнгөн урамшууллыг олгосон атал тус бүр нэг сарын үндсэн цалингийн 100.0 хувьтай тэнцэх буюу нийт 4,302.0 мянган төгрөгийн урамшууллыг давхардуулан олгосон байна. Үүнд:

- Тус төвийн дарга О.Ганбатад 1,621.0 мянган төгрөг,

- Ахлах нягтлан бодогч Б.Гантуяад 1,471.0 мянган төгрөг,
- Нярав С.Жавхланд 1,210.0 мянган төгрөг,

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно:", 15.1.3 : "Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох" гэсэн заалтыг зөрчсөн байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,023.7 мянган төгрөгийн алдаа¹ илэрснийг аудитын явцад залрууллаа. Үүнд:

- Агаараас дээж авах мини памп хөрөнгийн ашиглах жилийг буруу тооцсоноос 302.1 мянган төгрөгийн элэгдлийн зардал дутуу тайлагнасан,
- Тайлант онд худалдан авсан 721.6 мянган төгрөгийн үнэ бүхий багажийн иж бүрдлийг шууд зардлаар тайлагнасныг сэлбэг хэрэгсэлд бүртгүүлсэн.

Аудитаар нийт 8,874.0 мянган төгрөгийн зөрчил² илэрч зөрчлийг арилгах, давтан гаргахгүй ажиллах албан шаардлага хүргүүлэв.

5.1 Албан шаардлага

5.1.1. Тус байгууллага нь сүүлийн 3 жил дараалан буюу 2021 онд 7,869.0 мянган төгрөгийн, 2022 онд 10,838.7 мянган төгрөгийн, 2023 онд 10,644.5 мянган төгрөгийн буюу дунджаар 9,784.0 мянган төгрөгийн өөрийн үйл ажиллагааны орлого төвлөрүүлсэн, тус төвийн үзүүлж буй үйлчилгээний хөлс, үнэ тарифыг дунджаар 50 хувиар нэмэгдүүлсэн атал 2024 оны өөрийн орлогыг нэмэгдүүлэлгүйгээр 1,000.0 мянган төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 20,549.5 мянган төгрөг төвлөрүүлэн, төлөвлөгөөнөөс давсан 19,549.5 мянган төгрөгийг нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлэн зарцуулсан байна.


Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Сангийн сайдын 2022 оны А/282 дугаар тушаалаар баталсан "Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам"-ын 3 дугаар зүйлийн 3.6 дахь "Энэ журмын 3.1.1-т заасан орлого /төлөвлөгөөнөөс давж биелсэн орлого/ -ын сүүлийн 3 жилийн гүйцэтгэл болон...үндсэн үйл ажиллагаанд хамаарч үргэлжлэх байдлыг тус тус харгалзан төсвийн захирагчийн жилийн орлогын төлөвлөгөөг нэмэгдүүлнэ" гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Шийдвэрлэсэн нь: Үндсэн үйл ажиллагааны орлогыг бодит гүйцэтгэлд үндэслэн үнэн зөв төлөвлөж байх албан шаардлага хүргүүлэх.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
	Хөрөнгийн ашиглах жилийг буруу тооцоноос элэгдлийн зардлыг дутуу тооцсон	1	302.1			1	302.1	1	302.1			
Бараа материалыг шууд зардлаар тайлагнасан	1	721.6			1	721.6	1	721.6				
Дүн	2	1,023.7			2	1,023.7	2	1,023.7				

/мянган төгрөгөөр/

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөр-ийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Өөрийн үйл ажиллагааны орлогыг бодит гүйцэтгэлд үндэслэн үнэн зөв төлөвлөөгүй	1	8,874.0			1	8,874.0						
Нийт дүн	1	8,874.0			1	8,874.0						

Үүнээс

/мянган төгрөгөөр/



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 19 өдөр

Дугаар 17/А1871319

Сүхбаатар

СЭА-2025/023/НА-СТА-ТЦЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Сэлэнгэ аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Тус байгууллага нь сүүлийн 3 жил дараалан буюу 2021 онд 7,869.0 мянган төгрөгийн, 2022 онд 10,838.7 мянган төгрөгийн, 2023 онд 10,644.5 мянган төгрөгийн буюу дунджаар 9,784.0 мянган төгрөгийн өөрийн үйл ажиллагааны орлого төвлөрүүлсэн, тус төвийн үзүүлж буй үйлчилгээний хөлс, үнэ тарифыг дунджаар 50 хувиар нэмэгдүүлсэн атал 2024 оны өөрийн орлогыг 1,000.0 мянган төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 20,549.5 мянган төгрөг төвлөрүүлэн, төлөвлөгөөнөөс давсан 19,549.5 мянган төгрөгийг нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлэн зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Сангийн сайдын 2022 оны А/282 дугаар тушаалаар баталсан "Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам"-ын 3 дугаар зүйлийн 3.6 дахь "Энэ журмын 3.1.1-т заасан орлого /төлөвлөгөөнөөс давж биелсэн орлого/ -ын сүүлийн 3 жилийн гүйцэтгэл болон...үндсэн үйл ажиллагаанд хамаарч үргэлжлэх байдлыг тус тус харгалзан төсвийн захирагчийн жилийн орлогын төлөвлөгөөг нэмэгдүүлнэ" гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, даван гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана", 4.2.1.11 "Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн..." гэж заасныг тус тус үндэслэн

ШААРДАХ нь:

432504349

1. Дээрх зөрчлийг арилгаж, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид холбогдох хууль, тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Сэлэнгэ аймгийн УЦУОШТ-ийн дарга О.Ганбат, нягтлан бодогч Б.Гантуяа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

Э.ЭНХБҮРЭН